

ЭКОЛОГИЙН ЁС ЗҮЙ ДЭХ БИОТӨВТ ҮЗЛИЙН ОНЦЛОГ

Р.Дарьхүү (Prof)

МУИС. НШУС.

Философийн Тэнхмийн эрхлэгч

Б.Насанбат (Магистр)

Нийслэлийн Архивын газрын мэргэжилтэн

Тухаар үг: Байгаль, хүн, зохист нэгдэл, амьдрал, амьд зүйлийн үнэ цэнэ

Гал утга: Энэ өгүүлэлд биотөвт үзэл нь экологийн ёс зүйн нэг үндсэн баримтлал болох тухай, энэхүү үзлийн гол зарчим, үзэл санаа болон түүний орчин үеийн ач холбогдлын талаар авч үзсэн болно.

Экологийн ёс зүй нь нийгэм ба байгалийн харилцан үйлчлэл, хүн ба байгалийн хооронд зөв зохист нэгдлийг тогтоох арга, зарчим, хэм хэмжээг судалдаг хавсарга ёс зүйн орчин үеийн нэг чиглэл юм. Өөрөөр хэлбэл байгаль дэлхийд эдийн засгийн утгаар илэрхийлж боломгүй гоо зүй, оюун санааны ач холбогдол агуулагдаж байдаг. Байгалийг хайрлан хамгаалж хойч үедээ дамжуулахын тулд байгалийг зохистой ашиглах ёс суртахууны хариуцлага хэрэгтэй байна.

Экологийн ёс зүй нь экологийн хямралын шалтгаан, үр дагаврыг судлах, улмаар түүний сөрөг нөлөөллийг багасгахад ёс зүйн гүйцэтгэх үүргийг судлах хэрэгцээ шаардлагаар хорьдугаар зууны сүүлийн арван жилд бие даан хөгжсөн харьцангуй залуу салбар ухаан юм. Энэ утгаар дэлхий нийтийг хамарсан аюул гамшиг, экологийн хямрал нүүрлэсэн өнөө үед хүн төрөлхтөн ёс зүйн ямар асуудалд илүү их анхаарах шаардлагатай байгааг үндэслэсэн үзэл бол экологийн ёс зүй юм.

Хүн ба байгалийн хоорондын харилцааны асуудал эртнээс эдүгээ хүртэл философийн судалгааны мөнхийн бөгөөд чухал сэдэв юм. Эртний философичид байгалийг бүхнээс дээгүүр тавьж, төгөлдөр гоо сайхан бүхий байгаль бол хүч чадал тэнхээгээрээ хүнтэй зүйрлэшгүй. Хүний бүх сайн сайхан бол байгальтай дассан зохицоноор л шийдвэрлэгдэнэ, тиймээс сайхан амьдрал гэдгийг байгальтай зохицохын үндсэн дээр бий болдог хэмээн сургаж байсан. Тухайлбал, Аристотель бодит байдлыг байгалийн бүтээгдэхүүн ба өөр эх үүсвэр бүхий бүтээгдэхүүн гэсэн хоёр хэсэгт ангилж, байгаль бол бий болж буй юмсын үүсэл, юмыг төрүүлдэг юмсын бүтэц дэх үндсэн зүйл, юмсын уг чанар дахь анхны хөдөлгөөний эх булаг гэж үзсэн. Тэрээр ургамал болон амьтад нь хэдийгээр үүсэж мөхдөг ч философичдын судалгааны зүйл болж чадна¹ гэж тайлбарлажээ.

Профессор Г.Лодойн үзлээр, “Шинэ үеийн өрнийн философид хүн бол байгалийн ноён, тийм ч учраас оюун ухааныхаа хүчээр байгалийг өөртөө үйлчлүүлдэг байх ёстой гэсэн хүнтөвт үзэл

¹ А.Н.Чанышев. Аристотель. [Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. 3 боть эмхэтгэл. | боть УБ., 2011. 83 дахь тал

баримтлалыг дэвшүүлсэн байдаг. Энэ утгаар тэд байгалийг зөвхөн шинжлэх ухааны объект, тиймээс хүн түүнийг идэвхтэй үйл ажиллагаагаараа удирдах ёстой хэмээн үзэж байжээ. Улмаар бие даасан салбар ухаанууд хөгжихийн хэрээр байгалийг хүн эрхшээлдээ оруулах зорилго хэрэгжиж, үүний нөлөөгөөр талхлагдсан байгаль бий болжээ. Энэ үеэс л эхлэн байгальд хандах ёс зүйн асуудал хурцаар тавигдаж, энэ чиглэлийн судалгаа эхэлжээ².

“Байгаль бол хүний амьдрал үүсэх орчин. Хүний бүхий л шинж чанар байгальтай холбоотой. Иймд хүн байгалийг зөвхөн ашиглах бус, эх хүн гэж хүндэтгэн хайрлах ёстой” гэсэн үзэл санаа орчин үеийн философид ч яригдаж байгаа. Энэ талаар Ф.Энгельс хэлэхдээ: “Хэрвээ хүн төрөлхтөн байгальтай хэрэглэгчийн байр суурьнаас харьцвал байгаль тийм үйлдэлийнх нь улмаас хүнд хатуу шийтгэл онооно”³ гэжээ.

Экологийн ёс зүйн үзэл санааны эх сурвалж нь натурфилософи, дорнын ёс зүйн үзэл (даосизм, хүнзийн сургаал, буддизм, зэн буддизм), үндэстнүүдийн байгалиа хамгаалах ёс заншил зэрэг болно. Б.Спиноза: “Орчлон ертөнц дээр оршин буй бүх юмс бидэнд нээлттэй бас хосгүй үнэ цэнэтэй. Бид түүнийг ашиглахын зэрэгцээ хамгаалах ёстой” хэмээсэн байдаг.

Экологийн ёс зүйн судалгаанд Ж.Харгроуворын “Enviromental Ethics” журналууд чухал үүрэг гүйцэтгэжээ. Тэрээр үзэхдээ: “Ирээдүйд философи ба экологийн ёс зүй хоёр нь нэгэн бүхэл зүйл болно гэдэгт итгэлтэй байна. Учир нь экологийн ёс зүй одоогийн байдлаар өөртөө метафизикээс эхлэн биотөвт үзэл хүртэл философийн бүхий л хүрээг хамарсан байна”⁴ гэжээ.

Экологийн ёс зүйн асуудал бол бидний хийж чадах, мөн хийх ёстой ёс суртахууны сонголтуудыг судалдаг. Байгалийн өмнө хүлээж буй бидний ёс суртахууны хариуцлага зугтаж болохооргүй ирээдүйн ач холбогдлыг агуулсан байдаг.

Экологийн ёс зүйд биотөвт үзэл ба хүнтөвт үзлийн мөргөлдөөнтэй учирдаг⁵. Хүнтөвт үзэл, биотөвт үзэл гэсэн хоёр үндсэн чиглэлээр экологийн ёс зүй нь хөгжиж иржээ. Эдгээр үзэл баримтлал нь агуулга болон зарчмын хувьд ялгаатай юм.

Хүнтөвт үзлийн хувьд хүнийг байгалийн эзэн гэж үзэн, хүн байгаль дэлхийг өөртөө захируулахыг хичээж, байгальд нөлөөлөх хүчирхэг зэвсгүүдийг бүтээж, түүний эзэмшигч болох талаар үзэл санааг агуулдаг. Өөрөөр хэлбэл, “Байгаль бол хүний өмч.

Энэ өмчөө хүн хэрэглэх учиртай”. Хүний үйл ажиллагааны зорилго бол байгалийг өөрийн амьдралын ая тухын тулд өөрчлөхөд чиглэж байдаг гэсэн энэ үзэл одоо ч хэвээр байна. Гэвч түүхээс харахад хүнтөвт үзлийг хүнээс байгальтай харилцах харилцаанд гол болгон баримтлах нь олон сөрөг үр дагавартай байгаа юм. Барууны олон оронд хүний эрх ашгийг бүхнээс дээгүүрт тавьснаараа эргээд хүн өөрөө эрсдэлтэй нөхцөлд хүрсэн жишээ олон байдаг. Үүний хамгийн тод жишээ бол экологийн хямрал юм. Өнөөдөр ч бид дэлхий нийтээрээ тэр эрсдэлтэй нөхцөлийг туулж байна.

Ийнхүү байгалийг хүнд захируулах үйл явц хүчтэй явагдаж байгалаас хүн “зөвхөн аваад бай” гэсэн зарчмаар ашиглаж ирсний шууд үр дагавар нь хүнээс байгальд ихээхэн дарамт

2. Г.Лодой. *Өрнө дахины философийн түүхийн товчоон*. XVII-XVIII зуун. УБ., 1998. 76 дахь тал

3. Ф.Энгельс. “*Байгалийн диалектик*”. УБ., 1982

4. Harkgrove Eug. C. *Foundations of Environmental Ethics*, Englewood Cliffs, 1989

5. Attfield R. *The Ethics of Environmental Concern*. N.Y., 1983. p.36

учруулж, байгаль орчныг доройтуулж байгаагаар илэрдэг.

Хүн төвт үзлийн сул талын тухай Э.Фромм өгүүлэхдээ: “Байгалийг эзэмдэх гэсэн үзэл нь бидэнд байгалийн баялаг хязгаартай гэдгийг харуулах бололцоо олгоогүй бөгөөд эцсийн эцэст тэр нь барагдаж, ингэснээр байгаль биднээс хариугаа маш хэрцгийгээр авах болно” гэсэн байдгийг анхаарах ёстой.

Харин биотөвт үзлээр, “Байгаль бол хаан” тиймээс хүн байгалийн хуулинд захирагдаж, түүнд зохицож амьдрах тухай биотөвт үзэл нь амьд биесийн амьдралыг хүндэтгэх, хадгалах асуудлыг голчлон судлана. Энэ утгаар биотөвт үзлийг амьдрал төвт үзэл гэж нэрлэж болно.

Одоо биотөвт үзлийн үүсэл, хөгжил хандлагын талаар авч үзье. Хүн төрөлхтөн “Байгаль бол хаан” гэсэн зарчмыг шууд биш ч гэсэн үзэл санаандаа тусгасаар ирсэн. Харин байгаль ба хүн бол нэгэн төрлийн үзэгдлүүд бөгөөд харилцан шууд хамааралтай болохыг эртнээс эдүгээ хүртэл олон философич авч үзжээ. Эрт үед хүмүүс байгалиас айж эмээх, түүнийг бишрэх хандлага илүү давамгайлж байсны дотор дорно дахины ард түмний хувьд байгальтай харилцах харилцаа нь юуны өмнө байгалийг эрхэмлэх, хүндэтгэх зан үйлээр илэрч байдаг.

Тухайлбал, эртний Энэтхэгийн жайнист сургаалын нэг агуулга нь аливаа амьд биед муу зүйл учруулахгүй байхад чиглэдэг байжээ. Тиймээс ч лам нар самбай авч явж, ус уухдаа заавал шүүж уудаг ба санамсаргүйгээр амьд биет ууж магадгүй гэж ийнхүү болгоомжилдог байна. Мөн жижиг шүүрээр урдах замаа шүүрдэж, шөнө гадуур явах зайлшгүй хэрэг гарвал заавал дэн барьж өчүүхэн жижиг амьтдыг гишгэж хөнөөхөөс сэргийлдэг байсан гэдэг. Мөн жайнизм ёсоор амьтай бүхэн сүнстэй байдаг. Сүнс болгон үхэшгүй мөнхийн байдлаараа бурхантай холбоотой. Тиймээс хувь хүн бүр бусдад саад тотгор учруулж болохгүй бөгөөд энэ ертөнц дээр амьдарч буй бүхий л зүйлд эелдэг харьцах ёстой. Сүнснүүд өөр өөрсдийнхөө амьдралыг бий болгодог. Сүнс кармагаас чөлөөлөгдөх үед чөлөөтэй, тэнгэр огторгуйн сүнс болон хувирдаг гэх мэтээр авч үзсэн нь хүн бүх зүйлийн амьдралд сайнаар хандах ёстой гэсэн санааг илэрхийлж байдаг юм.

Даосист Ян Жү “Хүн бол байгалийн жам ёсыг танин мэдэж, түүнийг дагаж зохицож амьдрах ёстой” гэсэн үзэл санааг анх дэвшүүлжээ⁶. Мөн Лаоз “Байгалийн хуулиудыг танин мэдэж, зан төлвөө түүнд зохицуулах ёстойг тэмдэглэсэн”⁷. Тэрээр “Орчлон танихуйн гэгээн шастир” бүтээлдээ: “... Би эх болсон байгалийг шүтдэг билээ. Би эх болсон байгалийн өгөөмөр хөхөөр тэжээгддэг билээ”⁸ хэмээн байгаль бол хувь хүний шүтэн хүндэтгэх зүйл болохыг онцолжээ. Мөн Хан улсын философич Дун Жу Шу үзэхдээ: “Хүн, тэнгэр, газар гурав нь бүх юмны үндэс юм. Тэнгэр тэдгээрийг төрүүлнэ. Газар тэдгээрийг үржүүлнэ. Хүн тэдгээрийг төгөлдөржүүлнэ”⁹ гэсэн байдаг.

Эртний хятадын натурфилософид хүн байгалийн амьтан болохыг, өөрийн оршихуйг хамгаалж бататгахын тулд байгалийн тухай аль болох ихийг мэдэх ёстойг анхааруулж байв¹⁰.

6. Р. Дарьхүү, Г. Эрдэнэбаяр *Философийн түүх*. УБ., 2006

7. Фэн Ю. Лань. *Хятадын философийн товч түүх*. УБ., 2003. 29 дэх тал

8. *Орчлонг танихуйн гэгээн шастир* /Орч. Г. Наранжаргал/. УБ., 2004. 27, 41 дэх тал

9. Р. Дарьхүү. Хан улсын үеийн хятадын философийн онцлог – “Философи, шинэ судлал”. № 253/4. УБ., 2006. 27 дахь тал

10. Р. Дарьхүү, П. Батхүү- *Инь ян философийн арга зүйн асуудалд* – “Философи, шинэ судлал”. УБ., 2011

Шинэ үеийн философид “Байгаль ба хүн нэгдмэл байх” үзлийг Л.Фейербах боловсруулжээ. “Байгаль ба хүн гэсэн хоёр үгээр миний сургаал буюу үзэл баримтлалыг илэрхийлж болох юм”¹¹ хэмээн хүн ба байгалийн нэгдмэл чанарыг философийн үүднээс үндэслэх зорилт дэвшүүлсэн байдаг. Хүн ба байгалийн харилцан үйлчлэлийн явцад хүн байгалийг, өөрийгөө, хүмүүс хоорондын харилцаагаа танин мэддэг бөгөөд хүн байгалийн харилцаа нь практик асуудал болохыг тэмдэглэж, “Ахуйн тухай асуудал бол практик амьдралын холбогдолтой юм”¹² гэж Л.Фейербах бичжээ.

Хүнийг байгальтай нэгтгэж буй гол субъект нь бодит хүн байгаа цагт л хүн ба байгаль, сэтгэхүй хийгээд ахуйн жинхэнэ нэгдлийг сэтгэж, ойлгож болох юм. Хүнээс байгальтай харьцах харилцаа нь хүмүүсийн хоорондын харилцаагаар нөхцөлдсөн байдаг ажээ. Түүнчлэн хүн, байгаль хоёрыг нэгтгэж байдаг гол шижим нь нийгэм байдаг.

Орчин үед биотөвт үзлийг үндэслэгчид нь А.Леопольд, Жин Харгроувор, А.Швейцер нар юм. Орчин үеийн биотөвт үзэл бол байгаль дээр оршин буй аливаа амьдралыг хүндэтгэхийг уриалж байдаг.

Эдгээр биотөвт үзэлтнүүд байгаль өөрөө өөрийгөө бүтээгч болохын хувьд дараах шинжтэй гэж үздэг. Үүнд: нэг талаас, байгаль нь хүн үүсэх бололцоог агуулж байдаг. Тиймээс хүн байгалиас төрдөг. Энэ нь хүн эхээс төрдөгтэй адил ойлгогдох зүйл учраас хоёр дахь шинж нь юм. Ер нь хүн төрөлхтөн өөр өөрийн онцлог хэв маягтай ч чухамдаа нэг эхлэлтэй. Тэр нь байгаль юм.

П.Тайлорын үзлээр, биотөвт үзэл нь өөр хоорондоо харилцан холбоо бүхий дараах агуулгаас бүрддэг. Үүнд: Нэгдүгээрт, ёс суртахууны үндсэн хандлага нь байгалийг хайрлахад чиглэх ёстой. Хоёрдугаарт, экосистемд хамаарах бүхий л амьд биесийн “амьдрал”-ыг хүндэтгэн үзэх, Гуравдугаарт, ёс суртахууны норматив зарчим нь байгалийг хамгаалах тухай асуудал байх ёстой¹³.

А.Леопольд/1887-1948/-ын бичсэн “Ойн үйлчилгээ”, “Элсэн хаант улсын хуанли”, “Дэлхийн этик” зэрэг бүтээлдээ экологийн сүйрлийн тухай асуудал бол философийн судлах зүйл мөн гэдгийг тодорхойлсон байна. Тэрээр байгаль дэлхий зөвхөн хүн төрөлхтөнд зориулагдсан уу?, Амьтдын эрх гэж чухам юу вэ? Тэдэнд эрх гэж бий юу?, Хүн төрөлхтөн амьтдын өмнө хариуцлага хүлээдэг үү?, Бид хойч үедээ санаа зовох хэрэгтэй юу гэх мэт хүний амьдрал ба хүнээс бусад амьдралуудын хоорондын асуудлыг чухалчилан дараах хариултыг өгсөн байдаг.

Байгаль дэлхий зөвхөн хүн төрөлхтөнд зориулагдсан уу? Байгалийн тухай ярьж байна гэдэг нь хүний ахуйн тухай ярьж байгаа хэрэг. Байгаль нь юмс өөрөө өөрийнхөөрөө байх үзэгдэл юм. Байгаль бол үргэлж өөрөө өсөж үржиж байдаг. Мод ургаж ой болно. Амьтан өсөж үржиж ан амьтан болно. Эндээс л байгалийн өөрөө өөрийгөө бүтээх үйл явц эхлэдэг. Хүн энэ үйл явцыг хүндлэх ёстой. Байгаль бол өөр дээрээ орших бүх зүйлст зориулагдсан. Хүн бол байгаль дээрх

11. Ахуйн философи. Эх бичгийн эмхэтгэл. УБ., 2008. 24 дэх тал

12. Г.Лодой. Хүн ба байгалийн харилцааны тухай Л.Фейербахын үзэл баримтлал – “Философи, шашин судлал” № 308/9. УБ., 2009

13. Taylor, Paul W., *Respect for Nature: A Theory of Environmental Ethics* (Princeton NJ: Princeton University Press, 1986. P. 9

хүнс тэжээлийн хэлхээний зөвхөн нэг л хэсэг юм.¹⁴ Хэсэг бүр нэг нэгнээсээ хамаарал шинжтэй учир бусад хэсэгтэй санаа тавих ёстой. Гэтэл зарим судлаач хүн бол байгаль дээрх хэлхээний оргил гэж үздэг. Ингэж үзсэн ч хамгийн дээд оргил болсон амьтан нь бусад амьтаддаа санаа тавих нь жам ёсны хэрэг бус уу. Хүнийг хэлхээний нэг хэсэг, эсвэл оргил гэж үзсний аль ч ялгаагүй хүн гэдэг амьтан бусад амьтнаа хайрлах ёстой гэсэн дүгнэлтэд тулж очдог.

Байгалиа хайрлан хамгаалах гэдгийн гол утга юу байна вэ? гэхээр хүн өөрийн ахуйгаа хамгаалах гэсэн утга байдаг. Хүний ахуй орчин ганцхан байдаг. Хүний ахуйг бий болгогч үндэс бол амьд байгаль. Гэтэл хүмүүс өөрөө өөрийнхөө ахуй орчин руу дайралт хийсээр байна. Энэ бол буруу үйлдэл юм гэдгээ мэдсээр байж шүү дээ. Уг нь хүн байгальтай харилцах ёс суртахуунтай байх ёстой. Тийм байж л хүний амьдрах орчин жинхэнэ утгаараа бүрдэнэ.

Амьтанд эрх гэж бий юу? Амьтдын эрх гэж чухам юу вэ? Байгаль дээрх бүх зүйл өөрийн гэсэн амьдрах эрхтэй байдаг. Бүх амьд зүйл /амьтан ургамал, хүн/ оршин тогтнох эрхтэй. Хүн бас байгальд амьдрах эрхтэй. Хүн өөрийн энэ эрхээ эдлэхийн зэрэгцээ бусад байгалийн зүйлийн эрхийг хүндэтгэх ёстой. “Хүндэтгэх” гэдэг нь ахуй орчноо хамгаалах гэсэн үйлдэлтэй шууд холбогдоно. Газар шороо, уул ус, ургамал, амьтан, агаар энэ бүгд нийлээд ахуйг бүрдүүлнэ. Хүн л ахуйгаа мэдэх ухаантай төрсөн. Амьтан өөрийнхөө инстинктээрээ ахуйгаа мэдэрдэг бол хүн ухамсарт үйлдлээрээ ахуйгаа мэдэрдэг.

Тиймээс хүн л амьдрах эрхийг ухамсарлаж чадна. Тэр нь ёс зүйгээр илэрч харагддаг. Өөрөөр хэлбэл “Экологийн хэрэгцээ шаардлага эволюцийн ирээдүйн нөхцөл байдлыг хангахын тулд хүний сөрөг нөлөөгөөр эвдэрч сүйдэх газар нутгийг ёс зүйгээр хамгаалах ёстой хэмээн био төвт үзэлтнүүд үздэг. А.Швейцерын үзлээр, “Бүхий л оршин буй зүйлс амьдрах эрхтэй. Биологийн зүйл бүр нь өөрийн гэсэн халдашгүй энэ эрхийнхээ хувьд бүгд адил тэнцүү үнэ цэнэтэй”. “Биологийн төрөл зүйлийг хамгаалах ёстой” гэсэн энэ үзэл санааг П.Тайлор илэрхийлэхдээ: “Байгалийн тэнцвэрт байдал нь ёс суртахууны хэм хэмжээнээс шууд хамаарахгүй. Гэхдээ ёс зүй нь чухал үүрэгтэй. Тухайн бодьгал бүр төрөлхийн үнэ цэнэтэй. Тиймээс бидний ёс суртахууны харилцаа бол дэлхий дээрх ховордсон төрөл зүйлийн амьдралтай харилцахад чиглэнэ¹⁵ гэж үзжээ.

Хүн төрөлхтөн амьтдын өмнө хариуцлага хүлээдэг үү? О.Леопольдын үзлээр, “Хүн бол бүх амьд зүйлсийн өмнө шууд хариуцлага хүлээх ёстой”. Гэвч удаан хугацааны туршид хүмүүс байгалийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлаагүй¹⁶ гэж үздэг. Эндээс бид амьтны эрхийг хамгаалах тухай асуудал бол бидний шууд хариуцлага мөн, гэвч энэ хариуцлагаа удаан хугацааны турш хүн төрөлхтөн үүрээгүй гэдгийг харж болно. Ёс зүйн хувьд “Био нэгдлийн тогтвортой байдалд тусалж буй бүхий л үйлдэл нь сайн, харин саад болж буй нь мунхаглал юм”¹⁷. “Хүн төрөлхтөн амьд бүх зүйлийн өмнө шууд хариуцлага хүлээж байдаг”¹⁸.

А.Швейцер ёс зүйн үндсэн ойлголт болох сайн ба мууг тодорхойлох шинж нь байгальд

14. Leopold Aldo. "A sand county almanac". Oxford university press, USA. 1968. p.201

15. Taylor, Paul W., Respect for Nature: A Theory of Environmental Ethics (Princeton NJ: Princeton University Press, 1986. P. 8

16. Leopold Aldo. "A sand county almanac". Oxford university press, USA. 1968 p.239

17. Leopold Aldo. "A sand county almanac". Oxford university press, USA. 1968 p.221

18. Ричард Б.Примак. Байгаль хамгааллын биологи. УБ., 2003. 74 дэх тал

хүн хэрхэн хандсанаар илэрхийлэгдэнэ гэж үзжээ. Түүний үзлээр, “Сайны илрэх мөн чанар нь “амьдрал”-ыг дэмжих хайрлан хүндэтгэхээс хамаарна. Харин муу үйлийн мөн чанар бол “амьдрал”-д хохирол учруулж, түүнийг сүйтгэж байгаар илэрхийлэгддэг. Тиймээс бидний амьтдын өмнө хүлээх үүрэг ёс суртахууны асуудалд хамаарна. Бидний ёс суртахууны үүрэг бол бүхний л амьд зүйлийн амьдралыг хамгаалахад чиглэж байдаг”¹⁹.

Ер нь хүн байгаль хоёрыг нэгтгэж байдаг гол шинж нь нийгэм байдаг. Нийгэмд мэдээж амьтдыг хэрэгцээндээ ашиглах шаардлага бий. Өнөө үед хамгийн гол нь хүн чадлынхаа хэрээр биш, хэрэгцээнийхээ хэрээр ашиглах тухай асуудал нь дэлхийн хамгийн тулгамдсан асуудал болоод байна. Өнөөдөр дэлхий дээр 7 тэрбум хүн амьд зүйлсээр хооллон амьдарч байна. 2050 он гэхэд 9 тэрбум хүн бол хүнсний хэрэгцээ 30 хувиар өсөх тооцоо байна. Энэ нь хүнсэнд, тансаг хэрэгцээнд ашиглагдах амьтан ургамлын тоо өснө гэсэн үг.

Гэтэл бидний амьтанд хандаж буй хандлага тэдний тоо толгойг цөөлөхөд чиглэсэн тийм хатуу ширүүн байгаа. Энэ хатуу ширүүн хандлага 2050 он хүртэл үргэлжилж, тэр хандлагыг даван туулсан амьтдаар 9 тэрбум хүн хүрэлцээтэй хооллож чадна гэдэгт итгэхэд хэцүү байна. Хүн төрөлхтөн амьтад бол хүнс мөн, эдгээр хүнсэнд хэмжээ хязгаар бий хэмээн тэднийг хайрлан үзэх ёстой. Бид өнөөдөр чадлынхаа хэрээр биш хэрэгцээний хэрээр гэдэг зарчмыг хүлээн авах хэрэгтэй.

Эдүгээ хүртэл нийгэмд “Хүн байгалийг яаж ч уран нарийн аргаар өөрчилж хувиргалаа гэсэн ч байгаль өөрөөрөө үлддэг”²⁰ гэсэн хандлага давамгайлж байсан. Гэвч өнөөдрийн бодит байдалд хүний үйл ажиллагааны дараа өөрөөрөө үлдэж чадсан байгаль хаана байна вэ? Судлаачдын тооцоолж байгаагаар, ирэх 10 жилд хүн ам дахин 1 тэрбумаар өснө гэсэн тооцоо гарсан байна. Гэвч энэ нь хүн ба байгалийн хувьд араасаа олон сөрөг асуудлыг дагуулах болно. Байгалийн доройтол, байгалийн нөөцийн хомсдол бий болохгүй байх баталгаа байхгүй.

Ийм нөхцөлд хүний үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчин сүйрч бохирдож байгааг зогсоох, экологийн хямралаас гаргах, экологийн соёл, ёс зүйн шинэ парадигм хэрэгтэй байна. Энэ талаар оросын академич Н.Н.Моисеев бичихдээ: “Биомандлын элемент болох хүн төрөлхтний уналтыг зогсоох нь мөн чанартаа шинэ иргэншлийн үүсэлд хүргэнэ. Энэ асуудал нээлттэй байгаа юм” гэжээ. Энэ чиглэлд экологийн болон ёс суртахууны шинэ императив шаардлагатай болов. Н.Н.Моисеевын үзлээр, “Экологийн императив бол хүний үйл ажиллагаагаар ямар ч нөхцөлд үл өөрчлөгдөх хүрээлэн буй орчны тийм шинжүүдийн зарим олонлог юм.” Харин ёс суртахууны императив бол нийгмийн журам дэглэмийн аюулаас хүмүүсийг хамгаалах шинэчлэгдсэн ёс суртахуун юм. Экологийн болон ёс суртахууны шинэ императив нь хүн төрөлхтний стратегийг бүрдүүлэгч гол зүйлс мөн. Хүн төрөлхтний стратеги нь тогтвортой хөгжлийн зам юм”²¹.

Энэхүү шинэ парадигмыг биотөвт үзэлд үндэслэн гаргаж тавих нь бидний ирээдүйд чухал үр дүнтэй. Мөн хэвшил болсон буруу үзлүүдээс татгалзах хэрэгтэй. Тухайлбал хүнтөвт үзэл гэх мэт. Хүн төвт үзлийн үүднээс, хүний амьдралыг тав тухтай болгоно гэсэн шинэ ойлголт гарч

19. Attfield, R. *The Ethics of Environmental Concern*. Oxford, UK, 1983.p29

20. В.А. Канке. *Философи. Орчуулсан Ж. Отгонбаяр, Т.Нэмхжаргал УБ.*, 2007. 123 дахь тал

21. Моисеев Н.Н. *Еще раз о проблеме экоэволюции*. //Вопросы философии//. 1998. № 8. С.26

ирснээр хүн өөрийгөө бусад биологийн зүйлээс дээгүүрт тавьжээ. Энэ нь л хүний амьдралын хэв маягийг тодорхойлох болсон. Тиймээс ёс зүй, ирээдүйн хариуцлагын талаарх асуудлыг хэн ч ярихаа болжээ. Үүнээс шалтгаалан орчин үед аж ахуйн болон нийгмийн улс төрийн бодлогод хэр их чухал шаардлагатай нь харагдах болсон.

Эдгээр нь яах ёстой вэ гэвэл, хүний орчноо хүндэтгэсэн, эрхэмлэсэн харьцаануудыг бий болгох ёстой. Гэтэл өнөөдөр улс төрийн системүүд, нийгмийн системүүд хүн гэдэг эцсийн эцэст хэн бэ? Хүнд эцсийн эцэст юу шаардлагатай вэ? гэвэл тэр нь байгаль мөн. Байгаль буюу амьд зүйл бүрийн хамтын амьдрал л хүний оршихуйг хамгаалж чадна.

Зарим судлаач биотөвт үзэл бол хүн төрөлхтний эсрэг парадигм хэмээн шүүмжилдэг. Ингэж шүүмжлэгчид хүний амьдралыг илүү сайн сайхан болгохын тулд байгалиас тодорхой золиос гаргахад татгалзах зүйл байхгүй. Хүний амьдралыг сайн сайхан болгоход бусад зүйлсийг хэрэглэх нь гарцаагүй гэж үздэг. Гэвч бид эдгээр шүүмжлэлийг бүрэн хүлээн авах боломжгүй. Учир нь экологийн хямралаас үүсэх сөрөг нөлөөлөл газар сайгүй бий болж, хүн өөрөө ч амьдрах орчноо аюулд оруулсаар байгаа юм.

Норвегийн философич Арне Несс гүн экологийн үзэл баримтлалыг боловсруулсан юм. Гүн экологийн ёс зүй бол энэ бүхэл бүтэн системийн нэг хэсэг нь мөн гэж үздэг. Түүний үзлээр: “Байгалийн баялгийг дураараа ашиглах нь буруу ингэснээрээ байгаль дэлхий дээр амьдрал байхгүй болно”. Үүнд:

–Байгаль дэлхий дээр оршин буй “сайхан амьдрал” бол хүн төрөлхтөн өөрийн болон амьд организмийн амьдралыг хүндэтгэх явдалд оршино. Хүн төрөлхтний амьдрал бол бодит үнэ цэнэтэй зүйл, харин амьд организмийн амьдрал бол төрөлх үнэ цэнэтэй зүйл. Эдгээр үнэ цэнэ бол байгаль дэлхий дээрх амьд организмын амьдрал нь хүн төрөлхтний тусын тулд зориулагдсан байдаг гэсэн хүн төвт үзлийг шүүмжилдэг.

–Амьд организмийн амьдралын онцлог шинж нэгдгээрийн ашиг тусын шинжийг илэрхийлж байдаг.

–Хүн төрөлхтөнд байгаль дээр оршин буй зүйлийн төрлийг устгах өөрчлөх эрх байхгүй. Хүн байгалийн төрөл зүйлийг устгаж өөрчлөхгүй байх нь хүн төрөлхтний өөрсдийнх нь амьдралд чухал хэрэгтэй.

–Хүн төрөлхтний амьдрал болон соёл иргэншлийн хөгжил нь амьд организмын бууралтыг бий болгосоор ирсэн. Өөрөөр хэлбэл: Хүн ам өсөхийн хэрээр амьд организм устаж үгүй болдог. Тиймээс бид ёс зүйтэй байх ёстой.

–Одоо хүн төрөлхтөн байгалийн амьд организмийн амьдралд хөндлөнгөөс хэтэрхий оролцож байна. Энэ оролцоогоо гааруулж байгаа учраас бид ёс зүйн тухай ярьж байдаг.

–Тиймээс тухайн улс орны төрийн бодлогоор энэ байдлыг өөрчлөж чадна. Улс төрийн бодлогоор эдийн засгийн, технологийн ба үзэл сурталын байгууллагаар дамжуулан байгалийг эзлэгчидэд нөлөөлөх бололцоо бий.

–Чанартай амьдралын стандарт улам ихээр өсөн нэмэгдэж буй энэ үед амьд организмын амьдралыг хүндэтгэх, төрлөх үнэ цэнийг хамгаалах үзэл санааны өөрчлөлт хийх нь чухал асуудал болж байна.

– Дээр дурдсан үзлээс байгалийн өмнө хүлээсэн хүний үүрэг харицлагыг асуудлыг шууд болон шууд бусаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Энэ үзлийн гол зарчим нь хүн өөрийнх нь бүтээл биш байгалийн үнэт зүйлийг зүй зохисгүй хэрэглэхийг тэвчих явдал юм.

“Хүний хүсэл хэрэгцээ тун олон талтай. Хүний оршихуйн мөн чанар болсон хэрэгцээ бол бусад хүнтэй, мөн байгаль дэлхийтэй холбоотой байх явдал юм. Энэ холбоо нь хүн амьдарч хөдөлмөрлөх гол нөхцөл мөн”²² хэмээн Р.Дарьхүү хүн төвт ба биотөвт үзлийг хослуулан авч үзжээ. Экологийн ёс зүйн дээр дурдсан үндсэн хандлагыг хослуулах нь экологийн хямралыг шийдвэрлэхэд илүү чухал ач холбогдолтой байх болно.

Энэ бүтдээс дүгнэн хэлэхэд, биотөвт үзлийн үүднээс “амьд зүйл” болгон өөрийн гэсэн үнэ цэнэтэй бөгөөд хүн төрөлхтөн тэднийг устгах эрхгүй. Биологийн зүйл бүрт өөр өөрийн амьдрал буй. Энэ амьдралын жам ёсонд халдаж болохгүй. Хүнээс гадна амьтан ургамал гэх мэт бүх амьтай зүйл байгаль дэлхийд амьдрах эрхтэй бөгөөд хүмүүс тэдний энэ эрхийг хамгаалах үүрэгтэй. Энэ үүргээ хүн төрөлхтөн биелүүлэх нь тэдний ирээдүйд ашигаа өгөх юм. Бид зүйл бүрийн амьдралыг хадгалахад анхаарснаараа илүү аюулгүй дэлхийг ирээдүй үедээ хүлээлгэн өгч чадах юм.

“Байгальд тулгамдсан асуудлыг байгаль өөрөө шийдвэрлэнэ, тиймээс хүн түүнд оролцох шаардлагагүй. Урсгалаар л тэр асуудал шийдэгдэнэ” гэсэн зарчим байсан бол өнөөдөр тэр асуудалд хүн оролц гэсэн зарчимд шилжиж байна. Биднээс болж элэгдсэн тонуулсан, бохирдсон байгаль дэлхий маань урсгалаар явах ч тэнхэлгүй болж байна. Биологийн төрөл зүйлийн төрөх, амьдрах, үхэх явцыг хүн дураараа өөрчилж байна. Тиймээс бид тэдгээрт хандах ёс зүйгээ өөрчлөн сайжруулах ёстой хэмээн үзсэн нь биотөвт үзлийн ач холбогдлыг бидэнд ойлгуулж байдаг.

НОМ ЗҮЙ

1. Ахуйн философи. Эх бичгийн эмхэтгэл. УБ., 2008
2. Р.Дарьхүү. Дорнын болон өрнийн философи дахь хүний асуудал”. УБ., 1996
3. Р.Дарьхүү, П.Батхүү- Инь Ян философийн арга зүйн асуудалд –“Философи, шашин судлал”. УБ., 2011
4. Р.Дарьхүү. Хан улсын үеийн хятадын философийн онцлог –“Философи, шашин судлал” № 253/4. УБ., 2006
5. М.Золзаяа. Экологийн ёс зүй –“Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй”. УБ., 2012
6. Г.Лодой. Хүн ба байгалийн харилцааны тухай Л.Фейербахын үзэл баримтлал– “Философи, шашин судлал”. №308/9. УБ., 2009
7. Орчлонг танихуйн гэгээн шастир / Орч. Г.Наранжаргал. УБ., 2004
8. Ричард Б.Примак. Байгаль хамгааллын биологи. УБ., 2003
9. А.Н. Чанышев. Аристотель. |Б. Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. 3 боть эмхэтгэл. | боть УБ., 2011

22. Р.Дарьхүү. Дорнын болон өрнийн философи дахь хүний асуудал”. УБ., 1996. 99 дэх тал

10. Фэн Ю. Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003
11. Ф.Энгельс. Байгалийн диалектик. УБ., 1985
12. Leopold Aldo. "A sand county almanac" Oxford university press, USA 1968
13. Attfield R. The Ethics of Environmental Concern. N.Y., 1983
14. Harkgrove Eug.C. Foundations of Environmental Ethics, Englewood Cliffs, 1989
15. Taylor, Paul W., Respect for Nature: A Theory of Environmental Ethics (Princeton NJ: Princeton University Press, 1986
16. Моисеев Н.Н. Еще раз о проблеме коэволюции - //Вопросы философии. 1998, №. 8

SUMMARY

The "balance of nature" is not itself a moral norm, however important may be the role it plays in our general outlook on the natural world that underlies the attitude of respect for nature. I argue that finally it is the good (well-being, welfare) of individual organisms, considered as entities having inherent worth, that determines our moral relations with the Earth's wild communities of life.

Bio-centric system of environmental ethics is opposed to human-centered ones precisely on this point. From the perspective of a life-centered theory, we have prima facie moral obligations that are owed to wild plants and animals themselves as members of the Earth's biotic community. We are morally bound (other things being equal) to protect or promote their good for their sake.